

Хуралдсан газар:	Улаанбаатар хот, 14210, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, ХХБ-ны төв байранд зайнаас буюу Investor.tdbm.mn цахим хаягаар хуралдав.
Хуралдсан өдөр:	2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр
Үргэлжилсэн хугацаа:	09:00-11:07
Хурлын дарга:	Рандолф Коппа
Хурлын нарийн бичгийн дарга:	Н.Нямсүрэн
Хурлын ирц:	09 цаг 00 минут эхэлсэн ирц 90.49% Санал хураалт эхлэх үеийн ирц 91.88%
Хуралд биечлэн болон цахимаар байлцсан:	Худалдаа, хөгжлийн банк ХК: О.Орхон – Гүйцэтгэх захирал; А.Энхмэнд - Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч; Ц.Ганбаяр - Хууль, эрх зүй хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч; Д.Энхтуяа - Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал; Т.Батжаргал - Хуулийн газрын захирал; Т.Даваажав - Хөрөнгө зохицуулалтын газрын захирал; П.Лхагвабуд - Стратеги, хөгжил, инновацын газрын захирал; О.Баярсайхан – Олон улсын банкны газрын захирал; Д.Нямсүрэн - Ногоон санхүүжилтийн албаны дарга. Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК аудитын байгууллага: Д.Мандахбаяр – Партнер н.Мөнхгэрэл – Менежер
Зохион байгуулах комисс:	Дарга: Н.Нямсүрэн – Төлөөлөн удирдах зөвлөлийн бичгийн дарга; Гишүүд: Ц.Ганбаяр - Хууль, эрх зүй хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч; Д.Энхтуяа - Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал; Т.Батжаргал - Хуулийн газрын захирал; Т.Даваажав - Хөрөнгө зохицуулалтын газрын захирал; П.Лхагвабуд - Стратеги, хөгжил, инновацын газрын захирал; Х.Ууганбаяр - Технологи, инновацын хэлтсийн захирал; Л.Сайнбаяр - Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын албаны гадаад харилцааны мэргэжилтэн.
Тооллогын комисс:	Дарга: Ч.Лхагвасүрэн – Дотоод аудитын газрын захирал; Гишүүд: Л.Анхбаяр – Эрх зүйн бодлогын хэлтсийн захирал; Б.Энхжаргал – Тусгай аудитын хэлтсийн ахлах аудитор; Х.Оюутсэцэн - Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын албаны хуульч.

Хөтлөгч О.Баярсайхан:

Сайн байцгаана уу? Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Худалдаа, хөгжлийн банк (цаашид “ХХБ” эсхүл “Банк” гэх)-ны 2024 оны амжилт, үр дүнгээ танилцуулахаар өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар та бүхэнтэй энэхүү цаг мөчид уулзаж байна. Энэхүү хуралд ХХБ-ны Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дарга Р.Коппа, Гүйцэтгэх захирал (цаашид “ГЗ” гэх) О.Орхон, Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК (цаашид “E&Y” гэх)-ийн төлөөлөгч болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комисс оролцож байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “ХЭХ” эсхүл “Хурал” гэх)-ийн өмнө дэлгэцэд танилцуулагдсан хурлын дэгийн дагуу зохион байгуулагдах тул та бүхнийг танилцсан гэдэгт итгэлтэй байна. Ингээд Хурлын ирцийн талаар мэдээлнэ үү хэмээн Тооллогын комиссын даргыг урьж байна.

Тооллогын комиссын дарга Ч.Лхагвасүрэн:

Сайн байна уу. Та бүхэнд Тооллогын комиссоос ирцийн мэдээг танилцуулъя. Нийт хувьцаа эзэмшигчдийн 90.49 хувийн ирцээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүчин төгөлдөр эхэлж байна.

**Хурлын дарга Рандолф Коппа:
[АНГЛИ ХЭЛНЭЭС ОРЧУУЛАВ]**

Эрхэм хүндэт ХХБ ХК-ийн хувьцаа эзэмшигч Хатагтай, Ноёдоо тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн ирц 90.49 хувьд хүрч хурал хүчин төгөлдөр болохыг баталгаажуулсан тул ХХБ ХК-ийн ХЭХ эхэлснийг мэдэгдэж байна. Хурлын үйл ажиллагааг албан ёсоор эхлүүлэхийн өмнө, 2024 онд онцгой амжилттай ажилласан үр дүнд үндэслэн ТУЗ нэгж хувьцаанд 2000 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн ба Монголбанк зөвшөөрөл олгосны дараа Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан олгохоор болсныг мэдээлмээр байна.

Энэхүү ХЭХ хуралд идэвхтэй оролцож буй та бүхэнд юуны түрүүнд гүн талархал илэрхийлж байна. Та бүхний мэдэж байгаачлан банкны 2024 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан эцэслэгдсэн бөгөөд 2024 онд банкны хувьд онцгой амжилттай жил байлаа. Ерөнхийдөө Монголын банкны салбар өмнөх оны томоохон өөрчлөлт, шинэчлэлийн үр нөлөөг бататгах, ирээдүйн тогтвортой өсөлтийн суурь бэхжүүлэхэд анхаарсан жил байлаа ХХБ олон нийтэд нээлттэй ХК болсон статусаа ашиглан засаглал ил тод байдал сайжруулах, зах зээл дэх өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд чиглэсэн олон санаачилгуудыг идэвхтэй хэрэгжүүллээ. Банкны салбар бүхэлдээ дижитал шилжилт, эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход голлон анхаарч, өсөлтийн чиг хандлагаа хадгалсан онцгой жил байлаа. Макро эдийн засагт гарсан энэ бүх эерэг үр дүн банкны сектор болон Худалдаа, хөгжлийн банкны гүйцэтгэлд онцгой сайнаар нөлөөллөө. Банк 2024 онд нийт актив, өөрийн хөрөнгө, олгосон зээл, харилцах хадгаламжийн хэмжээ зэрэг голлох бүхий л үзүүлэлтээр өндөр өсөлт үзүүлж чадсан. Банкны удирдлагын баг болон ажилтнууддаа гүнээ талархал илэрхийлэе. Гүйцэтгэх захирал танилцуулгадаа та бүхэнд 2024 оны үр дүнгүүдийн талаар илүү дэлгэрэнгүй танилцуулах болно.

ТУЗ нь дэргэдээ ESG буюу байгаль орчин нийгмийн хариуцлагын хороог байгуулан ажиллаж байгааг дуулгахад таатай байна. Та бүхний мэдэж байгаачлан 2023 оны 5-р сард хийсэн IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгийг ногоон, тогтвортой санхүүжилтийг дэмжихэд зарцуулагдсан билээ. 2024 оны 3-р улиралд IPO-оор татан төвлөрүүлсэн хөрөнгийн 100 хувь зориулалтын дагуу зарцуулсныг дуулгахад таатай байна. Бид хувьцаа эзэмшигчид болон ажилтнууддаа хамгийн өндөр үнэ цэнийг бий болгохоор хичээн ажиллаж ирсэн бөгөөд энэхүү хүчин чармайлтаа цаашид ч үргэлжлүүлэн ажиллах болно ХХБ-нд өндөр итгэл хүлээлгэж байдаг. Худалдаа, хөгжлийн банканд өндөр итгэл хүлээлгэж байдаг, хүндэт хувьцаа эзэмшигч та бүхэндээ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэрийн өмнөөс гүн талархлаа илэрхийлэе. Баярлалаа

Хөтлөгч О.Баярсайхан:

ТУЗ-ийн дарга Ноён Коппа танд баярлалаа. Өнөөдрийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан, 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах ба Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт, ТУЗ-ийн гишүүдийг сонгох болон Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах талаар хэлэлцэн шийдвэрлэхээр байна.

Гүйцэтгэх захирал О.Орхон:

Сайн байцгаана уу? Худалдаа Хөгжлийн Банкны эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч ноёд, хатагтай та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Монгол Улсын банк санхүүгийн салбарын хөгжлийн түүчээ болсон Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, 2024 оны ололт амжилтаа хамтдаа дүгнэж, ирээдүйн хөгжлийн стратегийг тодорхойлох хариуцлагатай мөчид хүрэлцэн ирсэн та бүхэнд гүн талархал илэрхийлж байна.

Хувьцаа эзэмшигч та бүхний итгэл, дэмжлэг, идэвхтэй оролцоо бол банкны тогтвортой өсөлт, амжилтын нэгэн үндэс гэдгийг тодотгон хэлмээр байна. 2024 он бол Монгол улсын эдийн засаг, тэр дундаа банк санхүүгийн салбарынхны хувьд сорилт гэхээсээ илүү боломжийг хослуулсан онцгой жил болж өнгөрлөө. Бид гадаад, дотоод орчны өөрчлөлтөд уян хатан зохицон ажиллаж, ТУЗ баталсан стратегийг тууштай хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаа. Үүний үр дүнд бид бүхий л үзүүлэлтээрээ бизнесийн үйл ажиллагаагаа сайжруулж, санхүүгийн чадамжаа улам бэхжүүлж ажиллаж чадсан гэж дүгнэж байна. Бид ашигт ажиллагаагаа нэмэгдүүлж, хөрөнгийн чанарыг дээшлүүлэн, ирээдүйн тогтвортой өсөлтийн үндсээ улам бүр баталсаар байна.

Энэхүү үр дүнгийнхээ онцлох хэдхэн өсөлтөөс дурдахад:

- Банкны 2024 оны санхүүгийн гүйцэтгэл бидний хүлээлтээс давж, ихэнх үзүүлэлтээрээ түүхэн дээд амжилтыг үзүүллээ. Ганц жишээ авч хэлэхэд цэвэр ашиг өмнөх оноос 97.5 хувиар өсөж, 300 тэрбум төгрөгт хүрсэн нь мөн л банкны 35 жилийн түүхэн дэх хамгийн өндөр үр дүнг бий болгож чадлаа.
- Банкны өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 7.7 нэгж хувиар өслөө. Энэ бол эрхэм та бүхний хөрөнгө оруулалт үнэ цэнээ улам бүр нэмэгдүүлж байгаагийн нотолгоо гэж бодож байна.

Улмаар олон амжилтаа бид улам бататган, 2025 онд олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлсэн, хариуцлагатай, дэвшилтэт банкны жишиг загварыг бүтээхээр урам зоригтой урагшилж байна. Хүндэт хувьцаа эзэмшигч Та бүхний санал, оролцоо, үнэлгээ нь бидний цаашдын үйл ажиллагаа, ирээдүйг тодорхойлох хариуцлагатай шийдвэрүүдэд чухал нөлөөтэй болохыг дахин онцлон хэлмээр байна.

Ингээд та бүхэнд 2024 оны банкны үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй танилцуулъя. Бид 2020 онд банкныхаа алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг шинээр тодорхойлсон. Урт хугацааны тэргүүлэх стратегийн дараах 3 чиглэлийг тодорхойлж баталсан билээ. 1 дүгээрт харилцагч төвтэй банк болох гэдэг маань харилцагч бүрийн хэрэгцээг гүн гүнзгий ойлгож, тэдэнд хамгийн сайн таарсан үйлчилгээг хүргэхийг бид зорьж ажилладаг. 2-т нь олон улсын бөгөөд Ногоон Банк болох. Үйл ажиллагаандаа олон улсын шилдэг туршлагуудыг нэвтрүүлж, хамгийн гол нь тогтвортой хөгжил ногоон санхүүжилтийг дэмжин ажиллах стратегийн зорилготой. 3 дугаарт Платформ банк. Эхний 2 зорилтод бид ямар замаар хүрэх вэ гэхээр технологид суурилсан шийдлүүдээр дамжуулан хэрэглэгчдэдээ цогц хялбар, үйлчилгээг санал болгоно гэсэн стратегийн чиглэлүүд байгаа. Эдгээр стратегийн хүрээнд бид дунд болон богино хугацааны төлөвлөгөө гаргаж, тэрийгээ амжилттай хэрэгжүүлэн, дунд хугацааны буюу 5 жилийн төлөвлөгөөг 4 жилийн дотор буюу 2024 оны эцсийн байдлаар амжилттай үр дүнд хүрснээ дуулгахад таатай байна. Эхний стратегийн хүрээнд бид байгууллагын зах зээл дээр мэдээж тэргүүлэх байр сууриа хадгална. Үүний зэрэгцээ жижиг дунд бизнесийн болон иргэдийн сегментэд амжилттай тэлэлт хийж хөдөлмөрийн зах зээл дээр эзлэх хувь хэмжээгээ нэмэгдүүлэх, ингэснээрээ активынхаа бүтцийг илүү боловсронгуй зохистой түвшинд аваачих зорилго тавин ажилласан. 2023 оны эцсээр буюу бидний ПРО хийсэн жилийн эцсээр нийт зээлд эзлэх 3 сегментийн хувийг та бүхэн харж байна Байгууллагын буюу Корпорейт сегмент 61%-тай. жижиг дунд бизнесийн сегмент 15%-тай Иргэдийн бизнес 24%-

тай байсан бол 2024 оны эцсийн байдлаар байгууллагын сегмент 50%-тай, жижиг дунд бизнес 19%, иргэд 31% гэсэн харьцаандаа бид амжилттай хүрч чадсан. Хэрвээ 2020 оныхоо одоо стратеги батлагдаж байсан үетэй харьцуулбал энэ харьцаа 80% нь байгууллагын банкны зээлийн багцаас бүрддэг, хорьхон хувь нь жижиг дунд бизнес болон иргэдийн сегмент нийлээд хүрдэг байсан бол 2025 оны эцэст хүрэх энэ стратегийн зорилготой 2024 оны эцсээр амжилттай хүрч 50/20/30 гэсэн харьцаандаа амжилттай хүрч чадлаа.

2024 онд эдийн засгийн хөдөлгөгч хүч болсон манай Монгол улсын уур уурхай, худалдаа үйлчилгээ, хөдөө, аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, барилга гэх мэт гол гол салбаруудад манлайлагч 2800 гаруй томоохон аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтарч ажиллалаа. Энэ нь манай байгууллагын сегментийн үеийн анх үүсгэн байгуулагдсанаас хойш манлайллыг тогтвортой хадгалж байна. Байгууллагын зах зээлийн нийт зэх зээл зээлийн 30%-ийг ХХБ хадгалж, нөгөө талдаа байгууллагаас татсан харилцах, хадгаламж, эх үүсвэрийн зах зээлд эзлэх хувь маань бас 20%-тай байна. Байгууллагын сегментэд үзүүлдэг гадаад худалдааны үйлчилгээ зах зээл дээр 39% буюу үнэлэхүй хувийг эзэлж байна. Монгол Улсын өнгөрсөн онд хэрэгжиж томоохон төсөл санхүүжилтэд ХХБ идэвхтэй оролцлоо. Үндэсний болон хөдөө, аж ахуйг дэмжих хөтөлбөр, ноолуурын бэлтгэл, мал мах бэлтгэлийн нөөцийн санхүүжилт, аялал жуулчлалын салбарыг дэмжих хөтөлбөр зэрэгт нийтдээ 192 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Өмнө хэлсэнчлэн байгууллагын зах дээр тэргүүлсэн хэвээр байна. Харилцах хадгаламж, зээлийн өсөлт өмнөх онтой харьцуулахад 7.2 нэгж хувиар өссөн нь үнэхээр өндөр өсөлтийг үзүүлж чадлаа. Цаашдаа жижиг дунд бизнес сегментдээ зөвхөн жижиг дунд бизнес эрхлэгчдэд, үйлдвэрүүдийг оруулдаггүй энэ сегментэд бизнес эрхлэгч мөн хамруулж оруулдаг. Одоогийн байдлаар нийтдээ идэвхтэй 87 мянга орчим жижиг дунд бизнес эрхлэгч нарт банкны бүхий л бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ, жижиг дунд бизнес эрхлэгчдийг хэрхэн бизнесийн цар хүрээгээ өргөжүүлэх, удирдлагын арга барилыг нь сайжруулах маш олон талын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Ингэснээр харилцах хадгаламж 36%, зээлийн багц 53% өссөн байна. Идэвхжүүлэлтийг нэмэгдүүлэхийн тулд зээлийн багц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн багцыг нэмэгдүүлэхэд маш олон ажлуудыг бид нар зогсолтгүй хийсэн. Шинээр бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, одоо байгаа зүйлээ хөгжүүлэх, инновац шингэсэн, цаг хугацаа хэмнэсэн, харилцагчийн үндэслэл, хүсэл зорилгод нийцүүлэх, олон улсын зах зээл дээрээс урт хугацааны хямд эх үүсвэр, ялангуяа ногоон болон тогтвортой эх үүсвэрийг олж, жижиг дунд бизнесийнхэнд олгох гэх мэт ажлууд дээр төвлөрч ажиллалаа. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний хувьд пос мерчантын үйлчилгээ, багц бүтээгдэхүүн, жижиг дунд бизнес эрхлэгчдийн зээлийн шийдвэрийн үйл ажиллагааг сайжруулах, шинэ систем, шийдэл гэх мэтчилэн олон зүйлүүдийг шинээр нэвтрүүлсэн. Нэмж хэлэхэд Америкийн олон улсын санхүүжилтийн корпорацаас нийтдээ 120 сая ам.долларын ногоон болон тогтвортой эх үүсвэрийг авах гэрээнд гарын үсэг зурж, анхны зээлийг эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих болон бизнесийн жижиг ногоон зээл гэсэн ийм бүтээгдэхүүнүүдийг зах зээлд амжилттай нэвтрүүлж чадсан. Иргэдийн сегментэд түрүүн би хэлсэн нийт зээлийн багцын 31 хувьд хүрсэн байгаа. Яаж энэ амжилтад хүрсэн бэ гэхлээр юуны түрүүнд идэвхтэй харилцагчдынхаа тоог 17%-аар өсгөж чадсан. Ингэснээр манай идэвхтэй харилцагчдын маань тоо 1 сая давж буюу 1 сая 95 мянга болж оны эцэст хүрсэн байгаа. Үүний үр дүнд зээлийн багцыг нийтдээ 61%-аар өсгөж, үүнээс хэрэглээний зээлийн багцыг 303%-аар өсгөж чадсан байна. Харилцах, хадгаламжийг 18%-аар өсгөсөн байна. Энэ нь иргэдийн зах зээл дээр хийж байгаа үсрэнгүй өөрчлөлт хийнэ гэсэн стратегид нийцэж байна. Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээгээ зах зээлд нэвтрүүлэх ажил өнгөрсөн жилээс үргэлжлээд явж байна. Жишээлбэл Бритто Cashback гэдгийг манай харилцагчид маш сайн мэддэг болсон. Үүгээрээ Бритто брэндийнхээ Lady, Эйнштэйн карт гээд залуучуудын сегментэд гаргасан карт, классик, Алтан, Премиум бизнес зэрэг картуудын бүхий л урамшуулал дээр Cashback олгож, манай харилцагчид маш сайн хэрэглэж сурсан байгаа. 2024 онд Монгол Улсаас виза картаар гадаадад гүйлгээ хийж байгаа нийт гүйлгээний 33%-аас буюу 3-ны 1-ээс дээш хувийг ХХБ дангаараа бүрдүүлж байна. Шинээр зах зээлд мастер картыг бас нэвтрүүллээ. Тэгэхдээ технологийн онцлог дижитал эрэнд мастер картыг биетээр харилцагчдаа санал болгоогүй, виртуал хэлбэрээр санал болгосон. Виртуал мастер карт дээрээ үндэслэн ApplePay үйлчилгээг Монгол улсад анх удаа 2025 он дөнгөж гараад мастер карт дээрээ холболттойгоор оруулж нэвтрүүлсэн байна. Мөн урд хөршийн Юнион Пэй картыг идэвхжүүлэн ажиллаж байна. Дижитал шилжилтийн стратеги хүрээнд иргэдийн бизнес, амьдралыг хөнгөвчлөх олон дижитал шийдлүүдийг нэвтрүүллээ. ТиДиБи онлайн аппликэйшныхаа үйлчилгээний системийнхээ архитектурыг шинэчлэх замаар одоо ачааллыг даах чадвар, ажиллах хурд зэргийг эрс сайжруулж үүний үр дүнд ТиДиБи онлайн үйлчилгээг идэвхтэй хэрэглэгчдийн тоо 23.5%-аар өссөн.

Харилцагчдын маань үйлчилгээ авах мэдээллээ шинэчлэхэд цаг алдахгүй байх нөхцөлийг нь бүрдүүлж, дэлхийн Монгол Улсын иргэн дэлхийн хаанаас ч байсан Дан системийг ашиглан ТиДиБи онлайнаар дамжуулан ХХБ-ны харилцагч зайнаас болох боломжийг бүрдүүллээ. Түүнчлэн салбарт биеэр ирэх шаардлагагүйгээр веб сайтаар дамжуулан нүүр царай таних технологийг анх удаагаа нэвтрүүллээ. Салбарт ашиглагдаж байгаа 16 төрлийн гар маягт үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн үйлчилгээнийхээ хурд үр ашгийг нэмэгдүүллээ. Зээл хүсэлт зээлийн хүсэлт гаргах үйл явцыг хялбаршуулж, иргэдийн цагийг хэмнэх зорилгоор бид орон сууц, автомашины зээл гэх мэт зээлийн хүсэлтүүдийг онлайнаар хүлээн авч харилцагчийнхаа авах боломжтой зээлийн хэмжээг урьдчилан тооцоолсноор маш хурдтайгаар зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг дижиталаар хүргэж байна. Үндсэндээ иргэдийн зээлийн бүх бүтээгдэхүүнүүдийг 100% дижитал болгож 2024 онд амжлаа. Хамгийн чухал нь одоо иргэн болон аж ахуйн нэгжүүдийн цахим хуудсаар дамжуулан ердөө 5 минутад багтаад зээлээ шийдвэрлүүлэн бараа авах боломжтой болгосон. ТиДиБи онлайнаар нэхэмжлэлд үндэслэсэн Цахим зээлийн шийдвэр гэсэн зүйлийг бүрэн автоматжуулалт, дижитал дэвшилтийн томоохон амжилтыг гаргалаа. Эдгээр шийдлүүд биднийг дижитал шилжилт хийх стратегийн зорилтдоо хэр ойрхон байгааг харуулж байна гэж үзэж байна.

Цаашлаад онцлох үйл ажиллагаануудыг дурдъя. Улаанбаатар хотод шинээр салбар гэхээсээ илүү дижитал, лайт салбар гэж нэрлэж байгаа. Дижитал цаасгүй, иргэдэд хурдан шуурхай үйлчилдэг салбаруудыг нээж байгаа. Харин орон нутагт нэлээн үйл ажиллагаагаа тэлэх ийм зорилготой байгаа. Сүүлийн олон жилийн хугацаанд орон нутагт салбар нээгээгүй байсан туршилтын журмаар Баянхонгор аймагт өнгөрсөн жил банкныхаа салбарыг нээлээ. Энэхүү салбар маань маш амжилттай үйл ажиллагаа явуулж, туршлага дээрээ үндэслээд энэ жил дор хаяж дахин 3 аймагт салбараа нээнэ гэсэн зорилготой ажиллаж байна. Банкны системд анх удаа агент банкны үйлчилгээ гэдгийг зах зээлд нэвтрүүллээ. Ингэснээр бидний одоо хүрч чадахгүй байгаа бусад аймаг, хот, суурин газруудад бусад үйл ажиллагаа явуулж байгаа санхүүгийн байгууллагуудаар дамжуулан банкныхаа бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулах, иргэдэд хүргэх ийм боломжийг нээсэн. Өөрөөр хэлбэл дижитал боломжуудаа ашиглан заавал биет салбар байгуулахгүйгээр банкныхаа үйл ажиллагааг Монгол Улсынхаа орон даяар хүргэх зорилттой ажиллаж байна. Вебсайтаа Канад улсын ImageX компанитай хамтарч шинэчиллээ. Салбар тооцооны төвүүдийнхээ өнгө төрх тохижилтыг олон улсын A1 Партнерс байгууллагатай хамтран сайжруулж байна. Банкныхаа үйлчилгээний ажилтнуудын дүрэмт хувцсыг бид нар Япон улсын Юникло брэндтэй хамтран шинэчлээд байна. Өмнө нь бид дотоодынхоо Мишээл Амазонко компанитай хамтарч хийж байсан. Ингээд харилцагчийнхаа үйлчлүүлэх тав тух, салбарын орчин тохижилт, дээрээс нь үйлчилгээний ажилтнуудынхаа соёл, өмссөн зүүснээс авхуулаад бүхий л зүйл дээрээ анхаарч ажилласан. Арай жоохон олон улсын гэдэг юм уу томоохон түвшинд харилцагч нартаа зориулж хийсэн ажлууд гэх юм бол Trade Finance худалдааны санхүүжилтийн форумыг 2024 онд бид 2 дахь жилдээ зохион байгуулаад, сая 2025 онд бас 3 дахь удаагаа зохион байгуулчихсан байгаа. 2024 онд Restore and Unlock гэдэг чиглэлээр олон улсын худалдаа түүний дотор худалдааны санхүүжилт, баталгаа, аккредитив зэрэг бүтээгдэхүүнүүдийг идэвхтэй ашиглуулах тал дээр амжилттай зохион байгуулсан. Анх удаагаа Be Lady гэж жижиг дунд бизнес эрхлэгч, ер нь манлайлагч эмэгтэйчүүдээ дэмжин бизнесийн боломжуудыг танилцуулах, эмэгтэйчүүдийн Монгол Улсын бизнесийн орчин, ер нь Монгол улсын амьдралд үүрч байгаа ачааг олонд таниулах, цаашдаа дэмжих, ямар бодлого барьж ажиллаж байгаа талаараа танилцуулсан маш сайхан арга хэмжээ болж өнгөрсөн. Монголд анх удаа зохион байгуулсан Mining Week and MinePro гэсэн арга хэмжээ зэрэг зохион байгуулалцсан. Үүнд банк платиниум спонсороор хамтарч ажиллаж уур уурхайн салбар, Монгол Улсын тэргүүлэх эдийн засгийн ач холбогдолтой салбараа дэмжиж ажиллалаа. Хуримтлалтай Монгол аяныг бид анх санаачилж энэ сайхан нэрийг өгч, иргэдийнх сегментийн түрүүний миний хэлсэнчлэн татан төвлөрүүлсэн хөрөнгө, хадгаламж, харилцахыг нэмэгдүүлэх тал дээр онцгой ач холбогдол өгч ажиллаж байгаа нэг зүйл маань энэ аян байдаг. Аяныг үргэлжлүүлж өнгөрсөн жил нийтдээ 600 мянга гаруй харилцагч тус аянд идэвхтэй хамрагдаж, 600 харилцагчийг урамшуулж, 2 харилцагч маань одоо таун хаусын азтанаар тодорсон. Энэ аян бол Монгол Улс даяар нэлээн танигдаж харилцагчид маань идэвхтэй оролцож, шинэ харилцагч татахад онцгой үүрэг үзүүлдэг бүтээгдэхүүн болсон. Мөн Хаппи Парк болон Монголын эдийн засгийн форум зэргийг зохион байгуулж, дэмжиж ажилласан. Олон улсын банк, ногоон банк болох томоохон стратегийн зорилт байдаг. Та бүхний харж байгаачлан 2024 оны байдлаар нийт SWIFT-ийн гадаад төлбөр тооцооны зах зээлийн 32%-ийг Монгол Улсаас хийж байгаа болон Монгол Улс руу орж ирсэн буюу хүлээж авсан нийт төлбөр тооцооны 32%-ийг ХХБ дангаараа хийж гүйцэтгэсэн. Энэ нь өнгөрсөн оноос 1.3% болон 4.2% нэгж

хувиар өссөн үзүүлэлт байна. Монгол улсын импортын аккредитивын тоонд эзлэх хувь 39%, экспортын аккредитивын дүнд эзлэх хувь нь 52%, Монгол улсаас гаргасан нийт баталгааны тоонд эзлэх хувь нь 29%, Монгол улсын нийт хүлээн авсан баталгааны тоонд эзлэх хувь нь 37% гэх мэт 29-өөс 52%-ийг гадаад худалдааны санхүүжилтийн зах зээл дээр эзэлж байна гэж ойлгох хэрэгтэй. Эдгээр нь бүгд 2023 оны тоонуудтай харьцуулахад бүгдээрээ өсөлттэй гарсан байгаа. Ногоон банк болохын хувьд харилцагчдадаа аль болох урт хугацаатай, богино бага хүүтэй, эх үүсвэрийг олон улсын зах зээл дээрээс татах тал дээр ажилладаг гэж та бүхэндээ танилцуулсан. Өнгөрсөн жил бид анхныхаа нэлээн томоохон хэмжээний эх үүсвэр буюу миний түрүүний хэлсэн АНУ-ын олон улсын хөгжлийн санхүүгийн корпорацаас авсан хөрөнгө оруулалт болон Монгол улсдаа анх удаа гаргасан 50 сая ам.долларын нийгмийн болон ногоон бондын эх үүсвэрүүдийг өнгөрсөн жилийн 2 дугаар хагас буюу өнгөрсөн жилийн эцсээр татан төвлөрүүлж чадсан. Ногоон зээлийн багц өссөн, 2023, 2022 онуудтай харьцуулахад 2 дахин гаран өссөн байна. Гэвч Банкныхаа системийн тоонд харвал зээлийнхээ тоогоор 14%, зээлийнхээ багцын хувьд буюу зээлийн үлдэгдлийнхээ хувьд 8%-ийг эзэлж байгаа. Тэгэхээр сая оны эцсээр олон улсын зах зээл дээрээс босгосон эх үүсвэрээ маш идэвхтэйгээр ногоон зээл гаргах шаардлага үүсэж байгаа. Бид он гаргаад маш идэвхийлэн ажиллаад энэ тоо маань 8-аас 10% руу одоогийн байдлаар дөхөж байна. Гол чиглэл бол мэдээж эрчим хүчний хэмнэлт гэдэг тал дээр түлхүү зээл өгч байгаа. Нөгөө талдаа бизнесийн ногоон зээлд түлхүү олгож байгаа. Тэгэхээр нийт ногоон зээлийн багцын маань бүтцийг харвал 84% нь бизнесийн ногоон зээл, 16% нь иргэдийн ногоон зээл эзэлж байна. Онцлох стратегийн хүрээнд ямар онцлох үйл явдлууд бий болсон гэвэл Монгол Улсын зээлжих зэрэглэл 2024 онд нэмэгдсэн. Үүнийгээ дагаад манай банкны ч гэсэн зээлжих зэрэглэл S&P-ийн хувьд B+, Moody's хувьд B2 болон өссөн байна. Энэ нь олон улсын зах зээл дээр олон жил завсарлаад байсан бондын буухиаг маань үргэлжлүүлэхэд маш том хувь нэмэр оруулсан.

Euro Money олон улсын нэр хүндтэй сэтгүүлээс “the Best Bank for Corporates” буюу Монгол Улсын шилдэг байгууллагын банкаар шалгарсан. 2024 онд Худалдаа, хөгжлийн банк нь Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас тодруулдаг ТОП-100 аж ахуйн нэгжийн жагсаалтын 6-д жагсаж, ТОП 10-д орсон өндөр амжилтаа дахин бататгалаа. Өмнө дурдсанчлан бид олон жилийн турш харилцаж, хамтарч ажилласны үр дүнд АНУ-ын ЗГ-ын санхүүжилттэй Хөгжлийн корпорац хэмээх Монгол Улсад төдийлөн үйл ажиллагаа явуулдаггүй байгууллагаас анхны тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг Монгол Улсдаа татаж чадсан. Түүнчлэн бид өнгөрсөн оны эцсээр 3 жилийн хугацаатай 300 сая ам.долларын бондыг амжилттай олон улсын зах зээл дээр худалдан борлуулж чадлаа. Мөн түрүүн хэлсэнчлэн Австри Улсын Венийн Хөрөнгийн Бирж дээр анхны 50 сая ам.долларын нийгмийн болон ногоон бондыг арилжаалж чадсан. Үүний 40 сая ам.долларыг 2025 онд ногоон зээлд олгосон бол үлдсэн 10 сая ам.долларыг нь нийгмийн зээлд олгох олгох үйл ажиллагаа явагдаж байна. Бүгд Найрамдах Франц Улс болон Монгол Улсын гадаад харилцаа, худалдаа өргөжиж байгаа. Саяхан томоохон хөрөнгө оруулалтын гэрээ УИХ болон ЗГ-аар батлагдаж байх шиг байна. Үүнтэй холбоотойгоор бид харилцаагаа өргөжүүлэх үүднээс Бүгд Найрамдах Франц Улсын төрийн өмчтэй BPIF банкттай стратегийн хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан. Бид АНУ-ын Bank of New York Mellon-д анхныхаа ам.долларын дансыг нээж, Монгол Улсаа ам.долларын төлбөр тооцооны системд буцаад холбож байсныг та бүгд санаж байгаа байх. Энэхүү Bank of New York Mellon-той харилцах харилцаагаа сайжруулснаар одоо дэлхийн 100 гаруй улс руу түргэн шуурхай, хямд өртөгтэй төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

Монгол Улсын аялал жуулчлалыг дэмжих ажлын хүрээнд БНСУ-ын Korea Tourism Organization байгууллагатай аялал жуулчлалыг дэмжих хамтын ажиллагааны санамж бичиг зурсан. Дараагийн олон улсын чиглэл дээр хийж байгаа онцлох үйл ажиллагаанууд гэвэл GIZ буюу ХБНГУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг байгууллагатай бид жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, чадавхжуулах, тогтвортой санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах зорилгоор SFME төслийг хамтран хэрэгжүүлж эхэлсэн. Энэ нь Олон улсын байгууллагатай хамтарч жижиг дунд бизнесийнхнийхээ чадавхыг дээшлүүлэх, цаашдаа урт хугацааны тогтвортой ногоон санхүүжилтийг авч хэрхэн ашиглаж, үйл ажиллагаа бизнестээ хэрэглэж болох вэ гэдэг тал дээр илүү ойлголт өгөх зорилготой. Даян дэлхийн ногоон хөгжлийн институт буюу GGGI-тай бид стратегийн түншлэлийг бий болгосон. Тогтвортой бөгөөд нүүрстөрөгчийн хий багатай эдийн засгийн өсөлтийг хурдасгах хамтын ажиллагааны хүрээнд банкны 100 гаруй ажилтанд сургалт хийж, 80 гаруй жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаагаа хэрхэн ногооруулж болох вэ гэдэг боломжуудын талаар сургалт зохион байгуулсан. Харилцагчдаа бизнесийн үйл ажиллагаагаа одоо ногооруулах

шийдлүүдийн нэг болох эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж, түүнийг барихад зориулсан “Ногоон барилга” арга хэмжээг зохион байгуулсан. Мөн Уур Амьсгалын Ногоон Сангийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд бид дэлгэцэд харагдаж буй томоохон ажлуудыг хамтдаа хийж байна. Үүнд, 2024 онд Уур Амьсгалын Ногоон Сангийн санхүүжилтээр бид нар Монгол Улсын хэмжээнд тогтвортой болон ногоон санхүүжилтийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх бэлэн байдлын хөтөлбөрийг амжилттай хийж дуусгасан. Мөн, “Монгол Улсын орон нутгийн ногоон хөгжлийг дэмжих бэлэн байдлын хөтөлбөр” гэдэг 2 дахь хөтөлбөрийг бид нар амжилттай хэрэгжүүлж эхэлсэн. Энэ нь Өмнөговь аймгийн Ханбогд сумыг хүнд ээлтэй, тогтвортой хөгжил бүхий ногоон хот болгон хөгжүүлэхэд зориулан “Ханбогдын хөгжлийн хурдасгуур сан” гэсэн Оюу толгойн дэргэдэх сантай хамтран ажиллаж, байгаль орчин болон санхүүгийн мэргэшсэн зөвлөхүүдтэй хамтран төслийн санал бичиг баримтыг боловсруулж, батлуулаад байна. Мэдээж бид зөвхөн харилцагч нартаа гэлтгүй өөрсдийнхөө үйл ажиллагааг байгаль орчинд ээлтэй байлгах үүднээс “Green Hur, Green office” арга хэмжээ, хог хаягдлын менежмент, тогоо тохируулья гэсэн олон арга хэмжээнүүдийг банкн дотроо хэрэгжүүлж байна.

Техник технологи, харилцагчдын хандлага зэрэг зүйлүүд хурдацтай өөрчлөгдөж байгаа учраас дижитал шийдлүүдийг хөгжүүлдэг байгууллагууд, финтек байгууллагуудтай бид хамтран ажиллаж, үнэ цэний гинжин хэлхээг үүсгэж, банк, харилцагч, түнш байгууллагуудын одоо экосистемийг бий болгох замаар платформ банк болно гэсэн урт хугацааны стратегийг хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хүрээнд онцлох хийсэн үйл ажиллагаанууд харагдаж байна. Corporate Gateway үйлчилгээ буюу байгууллагуудыг банкны Open API-д холбосноор үйл ажиллагааг нь илүү хурдан шуурхай явуулах ийм боломжийг нэмэгдүүлж байна. Нэмээд, бид картын гол төлбөр тооцооны системийг хариуцдаг Compass plus компанитай шинэ Gateway үйлчилгээ нэвтрүүлсэн. Дэлхийн номер нэг банк санхүүгийн программ хангамжийн компани болох Temenos компанийн Core system буюу транзактыг нэвтрүүлж байна. Дижитал банкны платформ буюу Infinity-г нэвтрүүлж байна. Ингэснээр та бүхний харж байгаачлан оо манай цахим болон биет гүйлгээний харьцаа 80:20 байсан бол улам өсөж 86:14-д хүрээд байна. Бидний оны эцсийн гол онцлох бүтээгдэхүүн бол Монгол Улсад анх удаа ХХБ-ны Мастер картыг Apple pay-тэй холбож, гар утас болон одоо бусад дижитал төхөөрөмж, Ipad, Apple watch-р дамжуулан шууд гүйлгээ хийдэг болсныг та бүгд маань сайн мэдэж байгаа байх. Ингэснээр бид маш богино хугацаанд 100 мянга гаруй харилцагчийг шинээр татаж чадсан том амжилттайгаар ажиллаж чадлаа. Бид Виза картын шинэ хувилбарыг ахиулж чадлаа. Олон улсын төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын стандартаа 8 дахь жилдээ бүрэн баталгаажуулж, тодорхой хэмжээгээр бас шинэчилж чадлаа. Би түрүүн хэлснээр Compass Plus-тай картын системүүдээ сайжрууллаа. SWIFT-ийн гадаад төлбөр тооцооны гүйлгээ шивэх болон хурдыг 50-60%-аар нэмэгдүүлж чадлаа. Дижитал дугаар дуудагчийг бид нэвтрүүлсэн. Ингэснээр харилцагч маань шууд онлайнгаар өөрт ойрхон байгаа аль нэг ХХБ-ны салбар дээр байгаа очер дугаарыг харж байгаад дуртай салбар дээрээ очиж үйлчлүүлдэг цоо шинэ системийг нэвтрүүлж, мөн Монголбанктай хамтран токен үйлчилгээний системийг бас нэвтрүүллээ.

Эцэст нь бид нар зөвхөн бизнес ашиг орлогыг хөөхөөс гадна бас нийгмийн хариуцлагынхаа хүрээнд маш их олон ажлуудыг хийдэг. Та бүгд мэдэж байгаа байх. Энд цөөхөн хэдээс нь товчхон дурдъя. Банкныхаа ажилтнуудын сэтгэл ханамж, амьдралын чадавхыг дээшлүүлэх зорилгоор зөгийн үүр хөтөлбөрийг жил бүр хэрэгжүүлж байна. Өнгөрсөн жил бид ажилтнуудынхаа цалинг 25%-аар нэмсэн. Энэ нь 2 дахь жилдээ дараалж 25%-аар нэмж байгаа. Сая 2025 он гараад бид дахин 25 хүртэлх хувиар нэмж байна. За ингээд бид болбол үндсэндээ 4 жилийн турш цалингаа 25 хүртэлх хувиар нэмэгдүүлж, үндсэндээ 4 жилийн дотор ажилтнуудынхаа цалинг 2 гаран дахин өсгөх ийм зорилт тавьсан ажиллаж байгаа. Мөн хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол руу чиглэсэн ажлуудаа үргэлжлүүлж, “Хязгааргүй мөрөөдөл” төслөө бид үргэлжлүүлсэн. Эх үрсийн эрүүл мэндийг дэмжих, эмч, эмнэлгийн ажилтнуудыг дэмжих, нийгмийн асуудлыг нь хурдан шуурхай шийдвэрлэх гэх мэтчилэн олон зүйлүүдийг хийсэн. Мөн, нэг зүйлийг онцолж хэлэх юм бол эх үрсийн эрүүл мэндийг дэмжих тоног төхөөрөмж худалдаж авч нийлүүлсэн байгаа. Орхон аймаг дахь бүсийн оношилгоо, эмчилгээний төвд нярайн шарлагын болон дутуу төрсөн ургийг бойжуулах инкубаторын аппаратыг манай банкнаас бэлэглэсэн. Тэгээд олон улсын арга хэмжээнүүдийг бид байнга ивээн тэтгэж дэмжиж ажилладаг. Ингээд онцлох үйл явдал, стратегийнхаа зорилт зорилгуудын хүрээнд хүрсэн ололт амжилтууд та бүхэндээ танилцуулж дууслаа.

Одоо эдгээр маань тоон үзүүлэлтээр хэрхэн буусан бэ гэдгийг та бүгдэд товчхон танилцуулъя. Энэ танилцуулгын араас банкны 2024 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг та бүхэнд танилцуулах, ТУЗ-өөс банкны үнэлгээнд өгсөн дүгнэлтийг та бүхнээр батлуулах учраас тэр хэсгүүд дээр тодорхой хэмжээний танилцуулга явна. Татварын дараах цэвэр ашгийн хувьд 2023 он буюу өнгөрсөн онтой харьцуулахад 97.5%, бараг 100%-ийн өсөлттэй гарч, 298.6 тэрбум төгрөгт хүрсэн байгаа. Ингэснээр нийт актив маань 12 их наяд байсан бол 2024 оны эцсээр 15 их наядад хүрсэн. Активын өгөөж 1.2%-аас 2% болж өссөн, активын өгөөж маань өнгөрсөн оныхтой харьцуулахад 23.3%-аар өссөн байна. Өөрийн хөрөнгийн өгөөж буюу яг хувьцаа эзэмшигчдийн, банкны өөрийн хөрөнгө маань 1.4 их наядаас 1.6 их наяд болж, 14.7%-аар өссөн. Ингэснээр манай өөрийн хөрөнгийн хөрөнгийн өгөөж маань 18.5 хувьд хүрч өнгөрсөн жилүүдтэй харьцуулахад 7.7 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна. Зээлийн багцын хувьд нийтдээ 6,5 их наядад хүрч, өнгөрсөн онтой харьцуулахад 21.4%-аар өссөн байгаа. Зөвхөн зээлийнхээ багцыг өсгөөд зогсохгүй, нийт банкныхаа активын чанар чанаргүй зээлийн хувь хэмжээг бууруулах тал дээр 2023, 2024 онд маш онцгой анхаарч ажилласан. Ингэснээрээ бид нар нэлээн томоохон эрс сайжралтыг үзүүлсэн байгаа. Та бүхний харж байгаачлан 2022 онд манай чанаргүй зээлийн хувь хэмжээ бараг 20 хувьд хүрч байсан бол 2023 онд 12% болж буураад, 2024 оны эцсийн байдлаар 4.7% буюу банкны системийн дундажтай адилхан болж, их хэмжээгээр буурсан. ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 73 тоот тогтоолыг үндэслэн 60 зээлдэгчийн 84,717,196,789.50 төгрөгийн активын Эрсдэлийн сангаас хаасан. Нөгөө талдаа харилцагчдаас татан төвлөрүүлсэн харилцах хадгаламжийн үлдэгдлээ 10.3 их наяд хүрч, 13.8 хувиар өссөн. Эцэст нь банкны секторт эзлэх хувь хэмжээний хувьд нийт активаараа 21%-ийг, нийт зээлийн хувьд 17.5%-ийг, харилцагчдын харилцах хадгаламжийн хувьд 23.9%-ийг, өөрийн хөрөнгийн хувьд 22%-ийг тус тус эзэлж байна. Тэгээд 2024 оны төгсгөлөөр бид Монголбанкнаас тавьдаг бүхий л шаардлага, зохистой харьцаануудыг бүрэн биелүүлж ажилласан. Хамгийн чухал 2 үзүүлэлтүүдийг нь харвал өөрийн хөрөнгийн хүрэлцээ 12% байх ёстойгоос 14.8%, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 25% байх ёстойгоос 49.5% буюу бараг 50%-ийн хөрвөх чадвартай гэсэн үзүүлэлтүүдтэй ажилласан байна. Ингээд бидэнд одоо итгэл өгч, стратегийн зорилго, зорилтууддаа хүрэхэд минь дэмжлэг үзүүлсэн хувьцаа эзэмшигчид, түүнийг төлөөлж байгаа ТУЗ та бүхэндээ талархсанаа илэрхийлье. Мөн мэдээж энэ бүх зүйлийг хамтдаа бүтээхэд хүчин чармайлт гаргаж, хоёргүй сэтгэлээр ажилласан банкныхаа нийт ажилтнуудад талархсанаа илэрхийлье. Баярлалаа.

Хөтлөгч О.Баярсайхан:

Та бүхэнд ХХБ-ны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар дэлгэрэнгүй танилцуулга хийсэн гүйцэтгэх захирал Ноён Орхон танд баярлалаа. Дараагийн асуудлуудыг танилцуулна уу хэмээн ХХБ-ны ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хатагтай Нямсүрэн болон Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал хатагтай Энхтуяа нарыг тус тус урьж байна.

Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал Д.Энхтуяа:

За сайн байцгаана уу, Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигч болон энд хуран цугларсан ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, Ажлын хэсгийн хамт олонд энэ өдрийн мэндийг хүргэе. Та бүхэнд Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнг танилцуулах гэж байна.

Гүйцэтгэх захирлын танилцуулсан үйл ажиллагааны тайлангийн үр дүнд ХХБ-ны санхүүгийн тайланг бид Банкны тухай хууль, Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн дагуу жил бүр олон улсын нэр бүх нэр хүнд бүхий Big Four гэж яригддаг олон улсын байгууллагуудаар хөндлөнгийн аудит хийлгэдэг байгаа. Бид 2024 оны санхүүгийн үйл ажиллагааны тайландаа E&Y компаниар хөндлөнгийн аудитыг хийлгүүлж, 2025 оны 3 сарын 26-ны өдөр хүлээж авсан байгаа. Хүлээж авсны дараа олон нийтэд мэдээлэх үүргийнхээ хүрээнд банкны веб сайт болон олон нийтийн хэвлэл мэдээллээр та бүхэнд танилцуулсан байгааг хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна. ХХБ ХК нь санхүүгийн тайлангийнхаа үр дүнг ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зүгээс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн мөнгөн гүйлгээг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бодитой илэрхийлсэн гэдгийг батламжилж, олон улсын аудитын байгууллагадаа хүргүүлсэн байдаг. Үүний үр дүнд ХХБ-ны санхүүгийн аудитын тайланг E&Y компаниас дараах дүгнэлтийг өгсөн байгаа. Дүгнэлтийг уншвал “бид буюу

Эрнст энд Янг Монголиа Аудит ХХБ ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх компанийн санхүүгийн байдал тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ. Бидний дүгнэлтээр дээр дурдсан санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар 31-ний өдрийн байдлаарх банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталж гаргасан нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв бодитойгоор илэрхийлсэн болно.” гэж дүгнэсэн байгаа. Энэхүү дүгнэлтийг бол та бүхэн танилцуулга болон банкны веб сайт, МХБ-ын вебсайтууд дээр байршуулсан танилцуулга дээрээс харах боломжтой. Эдгээрийн үр дүнд түрүүний танилцуулга дээр дурдсанчлан ХХБ-ны нийт актив нь 15 их наяд төгрөгт хүрч, татварын дараах ашигт ашигт ажиллагаа маань 298,6 тэрбум, бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлээд үзэх юм бол 308 тэрбум төгрөгийн үр дүнтэй ажилласан тайланг бид хүлээж авснаа танилцуулж байна. Та бүхэнд баярлалаа.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Нямсүрэн:

Сайн байцгаана уу? ТУЗ-ийн нарийн бичгийн даргын хувьд ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулъя. Хурлын эхэнд ТУЗ-ийн дарга маань өчигдөр буюу 2025 оны 4 сарын 24-ний өдрийн ТУЗ-ийн тогтоолын дагуу 2024 оны цэвэр ашгаас нийт хувьцаа эзэмшигчийн эзэмшигчдийн нэгж хувьцаанд 2,000.00 төгрөгийн ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргасныг танилцуулсан. Энэхүү танилцуулгад харуулж буйгаар тус тогтоолын дагуу ногдол ашиг олгохдоо зохицуулагч байгууллага буюу Монголбанкнаас зохих зөвшөөрлийг авах ба зөвшөөрөл ирсний дараа 30 хоногийн дотор та бүхэнд ногдол ашгийг хуваарилах болно. Холбогдох хууль, журмын зохицуулалтын дагуу хувьцаа эзэмшигчдийн жил бүрийн ээлжит хуралд ногдол ашгийн хуваарилалтын тайланг танилцуулах ёстой байдаг. Иймд, 2024 онд хуваарилсан ногдол ашгийн талаар танилцуулъя. 2024 онд ХХБ нь 2 удаа нэгж хувьцаанд 1033 төгрөг ноогдох ногдол ашгийг хуваарилсан. Ингэснээр нийтдээ 104.5 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ олгосон байгаа.

Дараагийн танилцуулах асуудал бол ХХБ-ны 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг танилцуулах юм. Өмнөх 2 танилцуулга дээр маань Банкны 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар нэлээд дэлгэрэнгүй танилцуулсан учраас би ТУЗ-ийн дүгнэлтийг товчхон танилцуулъя. Өнгөрсөн жилүүдтэй адилаар энэ жилд мөн ТУЗ-ийн гишүүдийн хараат бус, бодит үнэлгээнд суурилан “ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийн дагуу 2024 оны дүгнэлт”-ийг гаргасан. Ингэхдээ ТУЗ-өөс баталсан банкны урт болон дунд хугацааны стратегийн хэрэгжилт тухайн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд үндэслэн ТУЗ-ийн гишүүд маань үнэлгээг өгсөн байгаа. ТУЗ-ийн гишүүдийн зүгээс ТУЗ-өөс 2024 онд хүрсэн хэд хэдэн амжилтуудыг үнэлж, эцсийн үнэлгээг гаргасан. Тухайлбал стратегийн 3 зорилтын нэг болох харилцагч төвтэй банк банк болох дунд хугацааны зорилтын хүрээнд олон улсын банк санхүүгийн зах зээлд нэвтрэх шинэ гарцыг нээсэн. АНУ-ын ЗГ-ын агентлаг болох Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпорацаас урт хугацааны санхүүжилт татсан, Австри Улсын Венийн хөрөнгийн бирж дээр ногоон болон нийгмийн ногоон бондыг амжилттай гаргасан. Мөн Платформ банк болох хүрээнд шинээр агент банкны үйлчилгээг амжилттай нэвтрүүлсэн, Тогтвортой хөгжил ногоон санхүүжилтийг дэмжих бодлогын хүрээнд жижиг, дунд бизнесийг дэмжих эмэгтэй бизнес эрх эрхлэлтийг дэмжих зорилго зорилтын хүрээнд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг зэрэг олон улсын байгууллага, мөн Дотоодын зээлийн батлан даалтын сан Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах хамтран ажиллаж ингэснээрээ жижиг дунд байгууллагын санхүүжилтийг нэмэгдүүлж жижиг дунд бизнес эмэгтэй бизнес эрхлэлтийг дэмжих зорилтынхоо хэрэгжилт зорилтоо амжилттай хэрэгжүүлсэн гэж үзэж байна. Мөн, Зөв бөгөөд хэрэгтэй хүн бол ХХБ-ны амжилтын түлхүүр, үнэ цэнтэй капитал гэсэн зорилтын хүрээнд банкны удирдлагаас бусад нийт ажилтнуудынхаа цалинг бүтээмжийн цалинг 3 дахь жилдээ нэмээд байна. Банкны маань нийт ажилтнуудын энэ бүх үзүүлсэн амжилт бол санхүүгийнхээ тайлан баланс дээр үр дүн нь харагдаж, ХХБ бол цэвэр ашгаа өмнөх оноос нэг дахин өсгөж, 2024 онд 298.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан, мөн нийт активаа 23,3%-аар өсгөж, өөрийн хөрөнгийн хэмжээ 14,7% хувиар өссөнөөр ХХБ нь олон жил явсан банкны салбарт эзлэх

тэргүүлэх байр сууриа хадгалж чадсан, ХХБ нь 2024 онд зөвхөн дотоодын зах зээл дэх байр сууриа хадгалаад зогсоогүй, олон улсад нэр хүндтэй найдвартай түнш болохоо дахин нотлон харуулсан жил болсон гэж дүгнээд ТУЗ-ийн гишүүдийн үнэлгээний дунджаар 2024 онд ХХБ-ны үйл ажиллагааг хэвийн буюу сайн ажилласан гэж дүгнэсэн дүгнэлтийг та бүхэнд танилцууллаа.

Өнөөдрийн хурлаар хэлэлцэн батлах дараагийн асуудлыг та бүхэнд товчхон танилцъя. Хууль, журам, зохицуулалтын дагуу ТУЗ-ийн гишүүдийг хэн нэг нь солигдсон тохиолдолд анх сонгоход кумулитив аргаар бүгдийг нь сонгосон бол дахин сонгохдоо бүх гишүүдээ кумулитив аргаар санал авч сонгох ёстой байдаг. Ингээд 2024 онд ТУЗ-ийн нэг хараат бус гишүүн нь өөр ажилд шилжих болсонтой холбоотойгоор шинээр нэг гишүүн ХХБ-ны хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа. Иймд, ТУЗ-ийн өнөөдөр 9 гишүүнээ дахин сонгуулахаар танилцуулж байна.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС
ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА**

 Ж.БОЛОРМАА 35+ жилийн туршлага	 Ж.ДЭЛГЭРСАЙХАН 30 жилийн туршлага	 Г.БАТЖАРГАЛ 20+ жилийн туршлага
БОЛОВСРОЛ - ОХУ, Иванова хотын Нэхмэлийн Дээд Сургууль - БНСУ, Хандоны Их Сургууль /СЭЗИС/, Бизнесийн удирдлагын магистр ТУРШЛАГА 1987 - 1990 онд Говь компанид мастер; 1990 - 1994 онд Худалдаа, Аж Үйлдвэрийн Дээд Сургууль, Эрдэм шинжилгээний ажилтан, багш; 1996 - 2007 онд МХБ, ажилтан; 2007 - 2015 онд СЗХ, Ахлах хянан шалгагч, газрын дарга; 2015 - 2018 онд Амаржаргал сан, ТУЗ-ийн дарга; 2015 оноос одоог хүртэл Ламын гэгээ монгол сүнчой ТББ, ТУЗ-ийн гишүүн; 2017 оноос одоог хүртэл ХХБ, ТУЗ-ийн хараат бус гишүүн. ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БҮЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ Хувьцаа эзэмшдэггүй.	БОЛОВСРОЛ - ХААИС, Эдийн засагч; - СЭЗИС, Санхүүгийн магистр; - МУИС, Хууль-эрх зүйч; - Удирдлагын академ, Төрийн удирдлагын доктор; ТУРШЛАГА 1995 – 2019 онд Машин механизм ХК, ТУЗ – ийн гишүүн, дарга; 1996 оноос одоог хүртэл СЭЗИС-д Багш, тэнхимийн эрхлэгч, зөвлөх; 1998 – 2000 онд Эм энд Жи Траст ХХК, Гүйцэтгэх захирал; 2006 – 2007 онд Машин механизм ХК, Гүйцэтгэх захирал; 2007 – 2009 онд Кибернетик ББСБ, Зөвлөх, Дэд захирал; 2017 оноос одоог хүртэл ХХБ, ТУЗ-ийн хараат бус гишүүн; 2024 оноос одоог хүртэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, гишүүн ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БҮЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ Хувьцаа эзэмшдэггүй.	БОЛОВСРОЛ - МУИС – Эдийн засгийн сургуул, “Банк” бакалавр; - МУИС – Эдийн засгийн сургууль, Бизнесийн удирдлагын магистр ТУРШЛАГА 2004-2010 - Монгол шуудан банк, дилер, ахлах дилер; 2010-2013 – Хадгаламж банк ахлах дилер, хэлтсийн захирал; 2013-2014 – Төрийн банк, Арилжааны хэлтсийн захирал; 2014-2020 – Улаанбаатар хотын банк, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал; 2020-2021 – худалдаа, хөгжлийн банк, Арилжааны хэлтсийн захирал; 2021 оноос одоог хүртэл Мони маркет фонд ХХК, Гүйцэтгэх захирал ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БҮЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ 0.00% Г.Батжаргалын бүрэн эрхийн хугацаа 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхэнэ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

 РАНДОЛФ КОППА 55+ жилийн туршлага БОЛОВСРОЛ - АНУ-ын Висконсин мужийн Мадисоны Их Сургууль, Олон улсын харилцаа; ТУРШЛАГА 1966 – 2004 онд 12 орны банк, санхүүгийн байгууллагад удирдах албан тушаалд, үүнээс 16 жилд нь ING банканд ажиллаж байсан арвин туршлагатай; 2004 – 2016 онд ХХБ, Гүйцэтгэх захирал, Ерөнхийлөгч; 2006 – 2013 онд МИК, ТУЗ-ийн дарга 2013 оноос одоог хүртэл Business Council of Mongolia, ТУЗ-ийн дарга; 2016 – 2022 онд ХХБ, ТУЗ-ийн гүйцэтгэх дэд дарга; 2022 оноос одоог хүртэл American Chamber of Commerce, ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн дарга; 2022 оноос одоог хүртэл ХХБ, ТУЗ-ийн дарга. ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БҮЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ Хувьцаа эзэмшдэггүй.	 Д.ЭРДЭНЭБИЛЭГ 30+ жилийн туршлага БОЛОВСРОЛ - МУИС, Эрх зүйч; - Монгол Улсын Удирдлагын Академи, Улс төр судлалын магистр; - СЭЗИС, Банк, санхүү. ТУРШЛАГА 2003 – 2006 онд Улаанбаатар хотын банк, ТУЗ-ийн дарга; 2006 – 2022 онд ХХБ, ТУЗ-ийн дарга; 2022 оноос одоог хүртэл ХХБ, ТУЗ-ийн гишүүн. ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БҮЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ Хувьцаа эзэмшдэггүй.	 Д.ХҮРЭЛБААТАР 40+ жилийн туршлага БОЛОВСРОЛ - Худалдааны техникум, Нягтлан бодогч; - ОХУ, Эрхүү хотын УАААДС, Банкны эдийн засагч; - Эрхүүгийн Марксизм Ленинийн Дээд Сургууль, Улс төрийн ажилтан. ТУРШЛАГА 1981 – 1991 онд Улсын банканд Улсын байцаагч, нягтлан бодогч; 1991 – 2005 онд ХХБ, Газар, хэлтсийн захирал; 2005 – 2007 онд Монгол шуудан банк, Дэд захирал; 2007 – 2021 онд ХХБ, Гүйцэтгэх захирлын орлогч, ТУЗ-ийн ажлын албаны дарга; 2020 оноос одоог хүртэл ХХБ, ТУЗ-ийн гишүүн; 2022 оноос одоог хүртэл Говь ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн. ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БҮЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ Хувьцаа эзэмшдэггүй.
---	---	--

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

 Д.ЯНЖМАА 45+ жилийн туршлага БОЛОВСРОЛ - Санхүүгийн Техникум, Банкны нягтлан бодогч; - МУИС, УААА-ны салбарын нягтлан бодогч, эдийн засагч. ТУРШЛАГА 1977 – 1990 онд Улсын банк, Нягтлан бодогч, Ахлах нягтлан бодогч; 1990 – 2003 онд ХХБ, Санхүүгийн газар, нэгжийн захирал; 2004 – 2007 онд Монгол шуудан банк, Санхүүгийн газрын захирал; 2007 – 2019 онд ХХБ, Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал; 2019 оноос одоог хүртэл ХХБ, ТУЗ-ийн гишүүн. ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БҮЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ Хувьцаа эзэмшдэггүй.	 А.ЭНХМЭНД 25+ жилийн туршлага БОЛОВСРОЛ - ШУТИС, Инженер-технологич; - ШУТИС, Инженер-технологич, магистр; - СЭЗИС, Нягтлан бодогч – эдийн засагч. ТУРШЛАГА 2004 – 2005 онд Интер банк, Дэд захирал, Гүйцэтгэх захирал; 2005 – 2020 онд Улаанбаатар хотын банк, Тэргүүн дэд захирал, Гүйцэтгэх захирал; 2020 оноос одоог хүртэл ХХБ, Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч; 2023 оноос ХХБ, ТУЗ-ийн гишүүн. ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БҮЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ Хувьцаа эзэмшдэггүй.	 Д.ОТГОНБИЛЭГ 25+ жилийн туршлага БОЛОВСРОЛ - МУИС – ЭЗДС, Эдийн засагч; - МУИС – ЭЗС, Бизнесийн удирдлагын магистр. ТУРШЛАГА 1997 – 1999 онд Сэргээн бослогын банк, Эдийн засагч; 1999 – 2001 онд Хадгаламж банк, нягтлан бодогч, Хянан шалгагч; 2001 – 2005 онд Интер банк ахлах ажилтан (Дотоод аудит); 2005 – 2007 онд Улаанбаатар хотын банк Дотоод аудитын газрын ахлах ажилтан, газрын захирал; 2007 – 2008 онд ХХБ, Дотоод аудитын газрын захирал; 2008 – 2011 онд ХХБ, Эрсдэлийн удирдлагын газрын захирал; 2011 – 2021 онд ХХБ, Гүйцэтгэх захирлын орлогч; 2021 оноос одоог хүртэл МИК ОССК ХХК, Дэд захирал; 2023 оноос одоог хүртэл ХХБ, ТУЗ-ийн гишүүн. ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-Д ЭЗЭМШИЖ БҮЙ ХУВЬЦААНЫ ХЭМЖЭЭ 0.00%
--	---	--

Ингээд ТУЗ-ийн гишүүдийг танилцуулж дууслаа. Баярлалаа.

Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал Д.Энхтуяа:

Та бүхэндээ дараагийн танилцуулгыг хийе. Дараагийн танилцуулга маань 2025 оноос 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болох хүртэл хугацааны ТУЗ-ийн багтлуулах асуудал юм. Худалдаа, хөгжлийн банкны ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлд заасны дагуу бид ТУЗ-тэй холбоотой дараах зардлуудыг багтаасан зардлыг батлуулдаг уламжлалтай. Үүний дагуу 2025-2026 оны хувьд бид 6 тэрбум төгрөгөөр уг зардлыг баталж өгнө үү гэж ХЭХ-даа танилцуулж байна. ТУЗ-ийн

зардалд дараах зардлууд багтдаг. Үүнд: ТУЗ-ийн дарга, гишүүдийн болон ТУЗ-ийн харьяаны нэгжүүдийн цалин хөлс, холбогдох татвар, шимтгэл; Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал, ТУЗ, түүний дэргэдэх хороодын хурлын зардал; Гадаад албан томилолтын зардал; Зочин төлөөлөгч, хүлээн авалтын зардал; Сургалт, мэргэжлийн бусад үйлчилгээний зардал; Бусад зардал (зар сурталчилгаа, хэвлэл, бичиг хэргийн зардал, өмчлөх бусад хөрөнгийн урсгал зардал болон бусад зардал гэх мэт).

Өнгөрсөн жилийн мэдээллээ өгөхөд 2024-2025 он буюу өнөөдрийг хүртэлх ТУЗ-ын зардлыг бид 5 тэрбумаар батлуулсан бөгөөд одоогийн байдлаар 4.9 тэрбум гаруй төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Бид өмнө хэлсэн ирэх жил хийгдэх ажлууд, стратегийн томоохон өөрчлөлтүүд болон түншүүдийн холбоотой нэлээдгүй асуудлуудыг шийдвэрлүүлэх зорилгоор бид нар зардлынхаа хэмжээг тодорхой хэмжээнд өсгөсөнтэй холбоотой 6 тэрбум төгрөгөөр ТУЗ-ийн зардлыг баталж өгнө үү хэмээн ХЭХ-д оруулж байна. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Хөтлөгч О.Баярсайхан:

Танилцуулгуудыг хийсэн ХХБ ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хатагтай Нямсүрэн болон Санхүүгийн удирдлага, хяналтын газрын захирал хатагтай Энхтуяа болон нарт талархлаа илэрхийлж байна. Ингээд танилцуулгатай холбоотой асуулт хариултын хэсэг үүгээр эхэлж байгааг та бүхэнд мэдэгдэж байна. Та асуултыг программын дээд буланд байрлах Асуулт, хариултын хэсэг гэдэг цэс дээр очиж асуултаа илгээх боломжтой. Та бүхэнд нэгэн зүйлийг анхааруулж хэлэхэд хурлын батлагдсан хөтөлбөрийн дагуух асуултад хариулт өгөх боломжтой. Асуулт хариултын үргэлжлэх хугацаа 10 минут. Хэрэв хурлын хөтөлбөрийн дагуу танилцуулсан асуудалтай холбоо холбогдолгүй асуулт хариултыг ирүүлэх юм бол бидний зүгээс хариулт өгөх боломжгүй байгаа тул энэ тохиолдолд бид хурлын дараа танд цахим шуудан болон бичгээр тайлбар өгөх боломжтой гэдгийг та бүхэн анхааралдаа авахыг хүсэж байна. Ингээд та бүхэн программын дээд хэсэгт байрлах цонхоор орж асуултаа илгээнэ үү.

[Хувьцаа эзэмшигчдээс асуулт ирүүлээгүй.]

Хөтлөгч О.Баярсайхан:

Асуулт хариултын хэсгийн дагуу асуулт ирээгүй байгаа тул хөтөлбөрийн дараагийн асуудал руу шилжье. Та бүхнийг ХЭХ-ын материалын 104 дүгээр хуудас болон дэлгэцэн дээр харагдаж буй тогтоолын төсөлтэй танилцан саналаа өгөхийг хүсэж байна. Гурван тогтоолын төсөлтэй бид бүхэн танилцана. Эхнийх нь “ХХБ ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай”, Хоёрдугаарх нь “ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай”, гуравдугаарх нь “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн ТУЗ-ийн зардлыг батлах тухай”. ХЭХ-аар хэлэлцэх асуудлуудын тогтоолын төслүүд та бүхний дэлгэцэн дээр гарч байгаа тул та бүхэн тогтоолын төслүүдтэйгээ дэлгэрэнгүй танилцаж, саналаа өгөх хэсэг рүүгээ бүгдээрээ ороход бэлдэцгээе.

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6, 29.2.7 дахь заалт, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.9 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Худалдаа, хөгжлийн банкны 2024 оны жилийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралтын дагуу баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
Н.НЯМСҮРЭН

РАНДОЛФ КОППА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа
эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны
өдрийн ээлжит хурлын 01 тоот тогтоолын
хавсралт

**ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
БОЛОН АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГСӨН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ**

Монголын банкны салбар 2024 онд өмнөх оны томоохон өөрчлөлт, шинэчлэлтүүдийн үр нөлөөг бататган, цаашидын тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлэхэд анхаарсан жил байлаа. Худалдаа, хөгжлийн банк (ХХБ) нь нээлттэй хувьцаат компани болсон статусаа ашиглан, засаглал, ил тод байдлаа улам сайжруулж, зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг идэвхтэй явуулсаар байна. Банкны салбар ерөнхийдөө өсөлтөө хадгалахын зэрэгцээ, дижитал шилжилт, эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох зэрэгт түлхүү анхаарсан нь 2024 оны онцлог байв.

ХХБ нь нээлттэй хувьцаат компани болсноор бэхэжсэн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн бүрэлдэхүүн 2024 онд банкны стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэв. Өргөтгөсөн, олон талт ур чадвартай ТУЗ нь банкны бизнесийн тасралтгүй өсөлтийг дэмжих, эрсдэлийн удирдлагын оновчтой тогтолцоог хэвшүүлэх, дотоодын болон олон улсын шилдэг туршлага, стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд чиглэсэн стратегийн удирдамж, зөвлөмжөөр тогтмол хангаж ажиллалаа. ТУЗ нь 2024 оны турш Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Банкны зохистой засаглалын зарчмууд болон ХХБ-ны дүрмийг үйл ажиллагааныхаа үндэс болгон, ТУЗ болон түүний дэргэдэх хороодын тогтоол, шийдвэрээр дамжуулан банкны үйл ажиллагааг чиглүүлж, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын эрх ашгийг дээдлэн, тэдний үнэ цэнийг өсгөхөд онцгой анхаарал хандуулав.

Банкны 2024 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлт нь ХХБ-ны урт болон дунд хугацааны стратегийн хэрэгжилт, тухайн жилийн батлагдсан санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд ТУЗ-ийн гишүүдийн хийсэн хараат бус, бодит үнэлгээнд суурилсан болно.

2024 онд ХХБ-ны Гүйцэтгэх удирдлагын баг болон нийт ажилтнууд ТУЗ-өөс баталсан стратегийн чиглэлийн дагуу банкны урт хугацааны зорилтууд болох:

- Харилцагч төвтэй байдлаа улам гүнзгийрүүлэх,
- Олон улсын зах зээл дэх байр сууриа бэхжүүлэх,
- Технологийн дэвшилд суурилсан, шинэлэг үйлчилгээ бүхий платформ банк болох алсын харааг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллаа. Эдгээр хүчин чармайлтын үр дүнд банкны актив, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлэх чиглэлээр төлөвлөгөөт зорилтуудыг ханган биелүүлэхээр хичээнгүйлэн ажилласан гэдэгт итгэлтэй байна.

2024 он нь стратегийн зорилтуудаа амжилттай ахиулж, зах зээл дэх манлайлал, олон улсын тавцан дахь нэр хүндээ улам бататган, инноваци, тогтвортой хөгжлийн чиглэлээр бодитой үр дүнд хүрсэн онцгой жил байлаа. Банкны урт хугацааны стратегийн гурван тулгуур чиглэлийн хүрээнд Гүйцэтгэх удирдлага болон нийт ажилтнуудын хүчин чармайлтаар 2024 онд дараах томоохон амжилтад хамтын хүчээр бид хүрлээ.

Харилцагч төвтэй банк болох зорилтын хүрээнд:

Банкны бүх үйл ажиллагааны төвд харилцагчийг тавьж, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн, орчин үеийн, хүртээмжтэй, найдвартай үйлчилгээг хүргэхэд онцгой анхаарал хандуулж, харилцагчийн туршилагыг тасралтгүй сайжруулж, ажиллалаа. Харилцагчдадаа дэлхийн жишигт нийцсэн, хялбар, аюулгүй төлбөрийн шийдлийг санал болгох зорилгоор ApplePay үйлчилгээг Монгол Улсад анхлан амжилттай нэвтрүүлж, дижитал төлбөр тооцооны шинэ боломжийг нээлээ. Харилцагчийн картын болон хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг олон улсын дээд түвшний стандартад нийцүүлэн ажиллаж байна. Харилцагчдад үйлчлүүлэх таатай, орчин үеийн орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үндэсний шилдэг компаниудын нэг AI Architects-тэй хамтран банкны салбаруудын дотоод интерьер, тохижилтыг шинэчлэх ажлыг эхлүүлж, үйлчилгээний чанарт бодит хөрөнгө оруулалт хийлээ.

Олон улсын банк болох зорилтын хүрээнд:

ХХБ нь олон улсын санхүүгийн зах зээлд Монгол Улсын болон өөрийн банкны нэр хүндийг өсгөх, дэлхийн жишигт нийцсэн үйл ажиллагаа явуулах, гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлээр 2024 онд томоохон алхмуудыг хийлээ. АНУ-ын Bank of New York Mellon-той тогтоосон ам.долларын ностро дансны харилцаагаа бататгаж, Монгол Улсыг дэлхийн ам.долларын төлбөрийн системд найдвартай, тасралтгүй холбох үүргээ амжилттай гүйцэтгэв. Түүхэн амжилт болгож, Монголын банк санхүүгийн байгууллагаас анх удаа АНУ-ын Засгийн газрын агентлаг болох Олон Улсын Хөгжлийн Санхүүжилтийн Корпорац (DFC)-аас шууд урт хугацааны санхүүжилт татсан нь Монгол Улсын бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, эмэгтэй бизнес эрхлэгчдийн өсөлт болон уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулах чухал эх үүсвэр болов. Мөн Австри Улсын Венийн хөрөнгийн бирж дээр олон улсын мэргэжлийн хөрөнгө оруулагчдад зориулан Монгол Улсаас анх удаа Нийгмийн болон Ногоон бондыг амжилттай гаргаж, дэлхийн топ 10-т багтдаг Ассет Менежмент компаниас хөрөнгө оруулалт татсан нь олон улсын тогтвортой санхүүжилтийн зах зээлд нэвтрэх шинэ гарцыг нээлээ. Эдгээр амжилтууд нь банкны санхүүгийн тогтвортой байдал, зөв засаглалын илрэл болж, олон улсын зэрэглэл тогтоогч Moody's агентлагаас ХХБ-ны зээлжих зэрэглэлийг B2 "Тогтвортой" түвшинд ахиулахад эергээр нөлөөлөв.

Платформ банк болох зорилтын хүрээнд:

Технологийн дэвшилийг үйл ажиллагаандаа үр дүнтэй нэвтрүүлж, банкны үйлчилгээний хүртээмж, үр ашиг, найдвартай байдлыг нэмэгдүүлэхэд чухал ахиц дэвшил гаргалаа. Төлбөрийн картын аюулгүй байдлын олон улсын PCI DSS 4.0 стандартыг амжилттай хангаж, 8 дахь жилдээ харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Банкны үйлчилгээг газарзүйн байршилаас үл хамааран хүргэх, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Агент банкны үйлчилгээг амжилттай нэвтрүүлж, банкны үйлчилгээг иргэдэд илүү ойртуулсан шинэлэг сувгийг бий болгов. Харилцагч, олон нийтэд зориулсан мэдээллийн гол суваг болох банкны вебсайтыг Канад улсын Image X компанитай хамтран орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж, дижитал орчин дахь хэрэглэгчийн туршилагыг сайжруулав.

Тогтвортой хөгжил ба хамтын үнэ цэн бүтээх:

ХХБ нь тогтвортой хөгжлийн зорилтуудыг үйл ажиллагаандаа тууштай хэрэгжүүлж, эдийн засгийн тулгуур хүч болсон жижиг, дунд бизнес (ЖДБ)-ийг идэвхтэй дэмжлээ. Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-тэй хамтран ЖДБ-ийг дэмжих "SFME" төслийг хэрэгжүүлэх гэрээ байгуулж, Дижитал Кредит ХХК-тай хамтын ажиллагаа эхлүүлэв. Түүнчлэн, Ханбогдын Хөгжлийн Хурдасгуур Оюу Толгойн сан, Даян дэлхийн ногоон хөгжлийн институт (GGGI), Нийслэлийн ЖДҮҮ-г Дэмжих Төв, Зээлийн Батлан Даалтын Сан зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг, гэрээ хэлэлцээрүүдийг байгуулж, бүс нутгийн ногоон хөгжил, ЖДБ-ийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал алхмууд хийлээ. Анх удаа эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан "BE LADY" форумыг амжилттай зохион байгуулж, жендерийн тэгш байдлыг дэмжих чиглэлээр хийсэн ажлуудаараа Тогтвортой Санхүүжилтийн Холбооноос "Жендерийн Манлай Байгууллага"-аар шалгарав. Мөн уламжлал болгон зохион байгуулдаг "Trade Finance Forum 2024" арга хэмжээ, EuroChamber Mongolia-ийн арга хэмжээ, UN-Day 2024 зэрэгт дэмжлэг үзүүлж, идэвхтэй оролцож ажиллаа.

Ажилтнуудын үнэлэмж, байгууллагын соёл:

Банкны амжилтын түлхүүр, хамгийн үнэ цэнтэй капитал болох нийт ажилтнуудынхаа уйгагүй хичээл зүтгэл, байгууллагын өсөлтөд оруулсан бодит хувь нэмрийг өндрөөр үнэлж, авьяаслаг боловсон хүчнээ тогтвортой ажиллуулан, урамшуулах бодлогынхоо хүрээнд гүйцэтгэх удирдлагаас бусад ажилтнуудын бүтээмжийн цалинг 25 хүртэлх хувиар нэмэгдүүлэх чухал шийдвэрийг гаргасан нь бидний зүгээс ажилтнууддаа талархал илэрхийлж буйн нэгээхэн хэлбэр гэж үзэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь Худалдаа, хөгжлийн банк 2024 онд өөрийн стратегийн гурван үндсэн чиглэлийн хүрээнд тодорхой зорилтуудыг амжилттай хэрэгжүүлж, олон улсын тавцанд байр сууриа бэхжүүлэн, харилцагч төвтэй соёлыг гүнзгийрүүлж, технологийн шинэчлэлийг нэвтрүүлснээр тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын манлайллаа бататгаж, бүх оролцогч талуудынхаа өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэн, үнэ цэнийг нэмэгдүүлсэн онцгой үр дүнтэй жил байлаа хэмээн дүгнэж байна. 2024 онд бий болгосон эдгээр бодит амжилтууд нь банкны цаашдын тогтвортой өсөлт, хөгжил дэвшлийн бат бэх үндэс суурь болж, ирээдүйн улам их амжилтад хүрэхэд түлхэц үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн үзүүлэлт

2024 онд санхүүгийн үйл ажиллагааны хувьд онцгой амжилт гаргаж, цэвэр ашгаа өмнөх оноос 97.5 хувиар өсгөн 298.6 тэрбум төгрөгт хүргэлээ. Энэхүү өндөр өсөлтөд банкны үндсэн орлогын сувгууд болох хүүгийн орлого 42.0 хувиар, шимтгэл хураамжийн орлого 24.8 хувиар тус тус эрчимтэй нэмэгдсэнээс гадна, зээлийн багцын чанарыг сайжруулах чиглэлээр авсан арга хэмжээний үр дүнд чанаргүй зээлийн хэмжээг 54.3 хувиар мэдэгдэхүйц бууруулж ажиллаж чадсан нь голлон нөлөөлөв. Мөн банкны 3 сегмент болох байгууллага, ЖДБ, иргэдийн сегментийн зээлийн багцуудын нийт багцад эзлэх хувийг 50/20/30 хувь болгох, эрсдэлээр жигнэсэн активын эзлэх хувийг 60/18/22 хувь болгох зорилтдоо хүрснээр төвлөрлийн эрсдэлийг бууруулж цаашдын бизнесийн өсөлтийн стратегийг хангаж ажиллаа.

Банкны нийт актив 23.3 хувиар өсөж, 15.0 их наяд төгрөгт хүрсэн нь тогтвортой өсөлтийг харуулж байна. Үүний зэрэгцээ, банкны санхүүгийн чадавх, тогтвортой байдлын илэрхийлэл болсон өөрийн хөрөнгийн хэмжээ 14.7 хувиар өсөж, 1.6 их наяд төгрөгт хүрсэн нь цаашдын өсөлт, хөгжлийн бат бэх суурийг улам бэхжүүллээ. Банкны зүгээс тогтвортой өсөлтийг хадгалахын зэрэгцээ эрсдэлийг оновчтой удирдах зорилтын хүрээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг 49.5 хувиар найдвартай түвшинд барьж санхүүгийн тогтвортой байдлыг ханган ажиллалаа. ХХБ нь 2024 оны эцсийн байдлаар Монгол Улсын банкны салбарын нийт активын 21.0 хувь (15.0 их наяд төгрөгийн активаараа), нийт зээлийн 17.5 хувь, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 23.9 хувь, нийт ашигийн 17.3 хувийг дангаараа бүрдүүлсэн нь банкны системийн нөлөө бүхий, тэргүүлэгч банкны байр сууриа тодотгон харуулсаар байна.

Эдгээр үзүүлэлтүүдээрээ ХХБ нь Монгол Улсын эдийн засаг, банкны салбарт эзлэх тэргүүлэх байр сууриа бататгаж, дотооддоо төдийгүй олон улсад нэр хүндтэй, найдвартай түнш болохоо дахин нотлон харуулсан амжилттай жил байсан төдийгүй ТУЗ-ийн гишүүдийн банкныг үнэлсэн үнэлгээний дунджаар 2024 онд үйл ажиллагаа хэвийн буюу “**Сайн**” ажилласан гэж дүгнэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.8 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг болон “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.10 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Дараах нэр дэвшигчдийг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгон томилсугай.

- 1.1. ...;
- 1.2. ...;
- 1.3.

2. Дараах нэр дэвшигчдийг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгон томилсугай.

- 2.1. ...;
- 2.2. ...;
- 2.3. ...;
- 2.4. ...;
- 2.5. ...;
- 2.6.

3. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнөх бүрэлдэхүүний бүрэн эрх дуусгавар болж чөлөөлөгдсөн болохыг дурдсугай.

- 3.1. Жалбаагийн Болормаа;
- 3.2. Жамсрандоржийн Дэлгэрсайхан;
- 3.3. Загдхүүгийн Нарантуяа /2024 оны 11 дүгээр сарын 4-ний өдрөөс/;
- 3.4. Рандолф Коппа;
- 3.5. Должингийн Эрдэнэбилэг;
- 3.6. Дагмидын Янжмаа;
- 3.7. Дамбийжавын Хүрэлбаатар;
- 3.8. Авгааны Энхмэнд;
- 3.9. Дэмчигжавын Отгонбилэг.

4. Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын дүрэм, журам, заавар, Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад шаардлагатай дүрэм, журам, зааврыг чанд баримтлан ёс зүйтэй, хариуцлагатай ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

РАНДОЛФ КОППА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Н.НЯМСҮРЭН

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.11 дэх заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025-2026 оны буюу дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрийг хүртэлх зардлын төсвийг 6,000,000,000.00 (зургаан

тэрбум) төгрөгөөр баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ДАРГА

РАНДОЛФ КОППА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН НАРИЙН
Н.НЯМСҮРЭН

БИЧГИЙН ДАРГА

Ийнхүү, ХЭХ-аар танилцуулах асуудлууд болон тогтоолын төслүүд танилцуулагдаж дууссан тул санал хураалтын хэсэгтээ бүгдээрээ орцгооё. Та бүхэнд одоо санал хураалттай холбоотой зөвлөгөө видеог хүргүүлэх тул энэхүү санал хураа зөвлөгөө видеотой анхааралтай танилцан санал хураалтаа өгөхийг хүсэж байна. Санал хураалтын үе шат 10 минут орчим үргэлжилнэ. Та бүхэн саналын хуудсаа тус хугацаанд багтаан бөглөж өгнө үү хэмээн хүсэж байна.

Санал хуудас бөглөх зааварчилгааны бичлэг. Саналын хуудас бөглөх гарын авлагатай танилцана уу. Та саналын хуудас бөглөхдөө дараах зүйлсийг анхаарна уу. Үүнд Санал өгөх заавартай сайтар танилцах, Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл хэсгийг гаргацтай алдаагүй бөглөх, Саналын хуудсыг бөглөхдөө хэлэлцэх асуудлын ард саналын хувилбараас зөвхөн нэгийг сонгож, харгалзах нүдэнд зөв тэмдэг эсвэл нэмэх тэмдгийн аль 1-ийг тавина. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн нэр дэвшигчийг сонгохдоо кумлятор аргаар санал хураах бөгөөд хувьцаа эзэмшигч та өөрийн эзэмшиж буй хувьцааны тоог 9-өөр үржүүлснээр таны саналын эрхийн тоо гарна. Хувьцаа эзэмшигч саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг эсвэл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй. Харин нэр дэвшигчид өгсөн саналын эрхийн нийлбэр таны саналын эрхийн тооноос хэтрэхгүй. Хэтэрсэн тохиолдолд таны санал хүчингүй болохыг анхаарна уу. Жишээлбэл хувьцаа эзэмшигч та 100 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг бол кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно. Та 900 саналын эрхийг бүгдийг нь ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно. Эсвэл ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй. Харин ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид өгсөн саналын эрхийн нийлбэр таны саналын эрхээс хэтрэхгүй байхыг анхаарна уу. Хувьцаа эзэмшигч та хувь хүн бол хувьцаа эзэмшигч хувь хүн бөглөнө. Хэсэгт хуулийн этгээдийг төлөөлөн оролцож байгаа бол хувьцаа эзэмшигч хуулийн этгээд бөглөнө. Хэсэгт мэдээллийг бөглөн гарын үсэг зурна аа. Санал өгсөн хувьцаа эзэмшигч танд баярлалаа.

Хөтлөгч О.Баярсайхан:

Санал хураалтын цаг ийнхүү дуусаж байна. Санал хураалтад идэвхтэй хамрагдсан эрхэм хөрөнгө оруулагч та бүхэндээ баярлалаа. Ингээд тооллогын комисс дүнгээ нэгтгэж хариуг мэдэгдэх хүртэл түр завсарлага авч байгааг ийнхүү мэдэгдэж байна. Эргээд удахгүй уулзацгаая.

[Завсарлага]

Хүндэт хувьцаа эзэмшигчид хөрөнгө оруулагчид аа ХХБ-ны 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын хугацаа дуусгавар болсон тул санал хураалтын дүн болон ХЭХ-ын шийдвэрүүдийн талаар танилцуулна уу хэмээн тооллогын комиссын дарга Ноён Лхагвасүрэн таныг урьж байна.

Тооллогын комиссын дарга Ч.Лхагвасүрэн:

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 3 асуудлаар санал хураалт явууллаа. За тооллогын комиссоос уг санал хураалтын дүнг тоолон баталгаажуулаад холбогдох шийдвэрүүдийг гаргасныг танилцуулъя.

“ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР

2025 оны ... дүгээр сарын-ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон тооллогын дүнгийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2 дахь заалт, 67.3.6 дахь заалт, 67.3.8 дахь заалт, 67.4 дэх хэсэг, 72 дугаар зүйл, “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.19 дахь хэсэг болон Худалдаа, хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд цахимаар болон цаасаар ирүүлсэн саналын эрхийг тоолсон тооллогын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн **“Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай”** асуудалд хурлаас гарах шийдвэр болон түүний төсөлд хувьцаа эзэмшигчдээс өгсөн саналыг тоолсон тооллогын дүнг доор дурдсанаар баталсугай.

Тооллогын дүн:

Зөвшөөрсөн 46,490,066 ширхэг хувьцаа буюу 99.99995 хувь;

Татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0.00 хувь;

Түдгэлзсэн 25 ширхэг хувьцаа буюу 0.00005 хувь.

2. “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай” асуудалд өгсөн саналыг тоолоход нийт 0 ширхэг хувьцаа буюу 0.00 хувьд эзлэх хүчингүй саналын хуудас байсныг дурдсугай.
3. Шийдвэрийн 1 болон 2 дугаар зүйлд заасан тооллогын дүнг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Тооллогын комиссын дарга (Ч.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Ч.ЛХАГВАСҮРЭН

**“ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР**

2025 оны ... дүгээр сарын ...-ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон тооллогын дүнгийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2 дахь заалт, 67.3.6 дахь заалт, 67.3.8 дахь заалт, 67.4 дэх хэсэг, 72 дугаар зүйл, “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.19 дахь хэсэг болон Худалдаа, хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд цахимаар болон цаасаар ирүүлсэн саналын эрхийг тоолсон тооллогын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн **“Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай”** асуудалд хурлаас гарах шийдвэр болон түүний төсөлд хувьцаа эзэмшигчдээс өгсөн саналыг тоолсон тооллогын дүнг доор дурдсанаар баталсугай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд өгсөн саналын эрхийг тоолсон тооллогын дүн:

Ж.Болормаа : Кумулятив саналын тоо 45,789,160 байна.

Ж.Дэлгэрсайхан : Кумулятив саналын тоо 45,789,026 байна.

Г.Батжаргал : Кумулятив саналын тоо 45,788,881 байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд өгсөн саналын эрхийг тоолсон тооллогын дүн:

Р.Коппа : Кумулятив саналын тоо 45,788,913 байна.
Д.Эрдэнэбилэг : Кумулятив саналын тоо 45,788,907 байна.
Д.Янжмаа : Кумулятив саналын тоо 45,788,916 байна.
Д.Хүрэлбаатар : Кумулятив саналын тоо 45,788,902 байна.
А.Энхмэнд : Кумулятив саналын тоо 45,788,997 байна.
Д.Отгонбилэг : Кумулятив саналын тоо 45,788,896 байна.

2. **“Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай”** асуудалд өгсөн саналыг тоолоход нийт 0 ширхэг хувьцаа буюу 0.00 хувьд эзлэх хүчингүй саналын хуудас байсныг дурдсугай.
3. Шийдвэрийн 1 болон 2 дугаар зүйлд заасан тооллогын дүнг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Тооллогын комиссын дарга (Ч.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Ч.ЛХАГВАСҮРЭН

**“ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР**

2025 оны 04 дүгээр сарын ...-ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон тооллогын дүнгийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2 дахь заалт, 67.3.6 дахь заалт, 67.3.8 дахь заалт, 67.4 дэх хэсэг, 72 дугаар зүйл, “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.19 дахь хэсэг болон Худалдаа, хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд цахимаар болон цаасаар ирүүлсэн саналын эрхийг тоолсон тооллогын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн **“Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай”** асуудалд хурлаас гарах шийдвэр болон түүний төсөлд хувьцаа эзэмшигчдээс өгсөн саналыг тоолсон тооллогын дүнг доор дурдсанаар баталсугай.

Тооллогын дүн:

Зөвшөөрсөн 46,490,063 ширхэг хувьцаа буюу 99.99995 хувь;
Татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0.00 хувь;
Түдгэлзсэн 28 ширхэг хувьцаа буюу 0.00006 хувь.

2. **“Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай”** асуудалд өгсөн саналыг тоолоход нийт 0 ширхэг хувьцаа буюу 0.00 хувьд эзлэх хүчингүй саналын хуудас байсныг дурдсугай.
3. Шийдвэрийн 1 болон 2 дугаар зүйлд заасан тооллогын дүнг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Тооллогын комиссын дарга (Ч.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Ч.ЛХАГВАСҮРЭН

Хөтлөгч О.Баярсайхан:

Санал хураалтын дүн болон хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрүүдийн талаар танилцуулсан тооллогын комиссын дарга Ноён Лхагвасүрэн танд баярлалаа. Ингээд ХЭХ-ын ээлжит хурлыг албан ёсоор хаан үг хэлнэ үү хэмээн хурлын дарга Ноён Коппа таныг тайзнаа урьж байна.

Хурлын дарга Рандолф Коппа:
[АНГЛИ ХЭЛНЭЭС ОРЧУУЛАВ]

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисс, Ernst and Young хөндлөнгийн аудитын төлөөлөгч, болон зохион байгуулах үйл ажиллагаанд оролцсон бүх хүмүүст талархлаа илэрхийлье. Бид бүгдээрээ Худалдаа хөгжлийн Банкны 2024 оны амжилтуудаа дүгнэж, өнгөрсөн жил нь бидний хувьд хувьсал өөрчлөлт, томоохон амжилтын жил байлаа.

2024 оны санхүүгийн гүйцэтгэл нь бидний стратегийн зөв байр суурь, үйл ажиллагааны үр ашигтай байдал, эрсдэлийн нягт нямбай удирдлага, хамт олны хичээл зүтгэлийн бодит илэрхийлэл юм. Энэхүү амжилттай жил нь ирэх он жилүүдэд хувьцаа эзэмшигч та бүхэндээ илүү өндөр өгөөж хүргэх итгэлийг бидэнд төрүүлж байна.

Энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт
2. Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгон томилов
3. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг баталлаа.

Үргэлж биднийг дэмжиж байдаг та бүхэндээ баярлалаа. Өсөлт, хөгжил, хамтын ололт амжилтаар дүүрэн ирээдүй байх болтугай.

Ингээд хурал албан ёсоор хаасныг мэдэгдэж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Н.НЯМСҮРЭН